

СУРГАЛТ ХҮМҮҮЖЛИЙН ҮНДСЭН ЗАРЧМУУДЫГ АДИЛ ТАЛТ ГУРВАЛЖИНГААР ТӨСӨӨЛӨХҮЙ


/треугольное представление об основных принципах педагогики/

Ч.Санчир

Барагдашгүй хэмээх Гал нохой жилийн босгон дээр “Дал” сонины ээлжит дугаар (№220/2)-ын “Багш нар бичиж байна” буланд боловсролын тогтолцоо ба хичээлийг шинэчлэх талаар гарсан хэд хэдэн өгүүлэл, нийтлэлтэй танилцаад эл ажилд хориод жил эчнээ хутгалдаж явсны хувьд саналаа нэмэрлэе гэж бодлоо. Боловсролын тогтолцоо, сургалтыг шинэчлэх талаар “Багш” сэтгүүлд академич, профессор О.Лхагва, боловсролын доктор Н.Нэргүй нарын ончтой хурц нийтлэлүүд урьд нь бас гарчээ. Энэ удаад профессор, доктор Я.Хишигтийн “Дал” сонины дараалсан хоёр дугаар (№220/2; №221/3) дамнуулсан өгүүлэлдээ толилуулан буй авууштай санаа, оновчтой зарчим, баримттай жишээг олзуурхахаас өөр аргагүй.

Тэрээр боловсролын шинэчлэлийг эн тэргүүнд нэр томьёоноос эхэлж “сурган хүмүүжүүлэх ухаан” гэдгийг “хүмүүжүүлэн сургах ухаан” хэмээхийг санал болгосон нь цаашид анхаарууштай асуудлын нэг мөн байна. Яагаад гэвэл, ургамлын ангилал зүйн шинэчлэх ухааны эцэг гэж алдаршсан их Карл Линней “нэрлэлгүй аваас аливаа шинжлэх ухаан юу ч биш болно” гэсэн байдаг.

Мөхөс миний бодлоор хүмүүжил, боловсрол, сургалт нь хэдийгээр өөр өөр ойлголт ухагдахуун боловч харилцан шүтэлцээ бүхий өвөр хооронд нь салгаж, зэрэглэж боломгүй, товчоор хэлбэл адил талт гурвалжин (Ар) лугаа адил юм.



Үүнээс үзэхэд, сурган хүмүүжүүлэх ухаан нь хэн хүнд хүмүүжил мэдлэг олгох, сурах ба сургах аргыг хослуулсан шинжлэх ухааны томоохон салбар аж. Сайтар ажаад байхнаа сургалтын бүх үйл ажиллагаа ч мөн л энэ тэр төсөөлөгдөж буй (Бр).



1. Сургалтын тухайд

Дээрх гурвалжингуудаас сурахгүйгээр хүмүүжиж, хүмүүжихгүйгээр боловсорч, номд боловсрохгүйгээр сургаж, сурч боловсрохгүйгээр бүтээж болдоггүй нь харагдана.



Боловсролын доктор Н.Нэргүй хүмүүжих, боловсрох хийгээд сурах технологи эзэмшихийг суралцахуй гээд Үүнийг сургалтын үндсэн хэсэг хэмээн томьёолсон нь бас л адил талт гурвалжин (Вр)-гаар төсөөлөгдөж байна.

Сурах технологи гэдэг нь суралцахын ур ухаан, эв дүй, сургалт судалгааны хувьд бол аргачилсан заавар (методическое указание), сурья технологитой болсон арга барил (методический приём)-ын цогц юм.

Гэхдээ сургалт нь суралцахуйг бодвол өргөн цар хүрээтэй, олон талт ойлголт бөгөөд сурснаа амьдралд хэрэгжүүлэх агуулгыг багтааснаараа илүү бүтээлч үйл ажиллагаа байдаг.

Эдгээртэй шууд уялдаа бүхий аргуудыг ч бас адил талт гурвалжин (Гр, Др)-аар илэрхийлж болно. Багш хүн заан сургах явцдаа өөрөө сурч боловсордог, нөгөөтээгүүр аливаа мэдлэг, чадвар, ур ухааны мэдрэмжүүд гагцхүү хүний үйл ажиллагааны хүрээнд бүрэлдэн төлөвшдөг дараах гурвалжин (Гр)-гаас харагдана.



Харин сэтгэж сургахын сургахын

тулд зарим хичээлийг мэтгэлцээний арга хэлбэрээр заах, сурагчдад тодорхой асуудал тавьж шийдвэрлүүлэх замаар явуулахын чухлыг доктор Б.Тогоочийн “Сурагчдын сурлагад мэтгэлцээний нөлөө” (“Дал” сонин, №220/2, 2006) өгүүллээс мэдэж болно.

Монгол ардын уламжлалт болоод орчин цагийн сургалтад тулгуурлан сонсож, уншиж, хийж сурах, сэтгэн бодох ба хийсвэрлэхүйн тухайд профессор О.Лхагвагийн өгүүллээс уншина гэдэгт найдан чинагш үл нурушюу.



Монголчуудын уламжлалт сургалтын цөм нь зааж сургах, заалгаж сурах явдал юм (Ер).



Гэхдээ “ном дор мөргөмүү” гэдэг нь зөвхөн багшаар дамжуулж бус биеэ дааж суралцахын нэг хэлбэр тул Монголчуудын уламжлалт сургалтыг заах, хэлэх, үзүүлэх өрөөсгөл талыг барьсан гэх нь бас учир дутагдалтай. Яагаад гэвэл, бидний дунд “эзэн хичээвэл заяа хичээнэ”, “эрлийг сургаар, эрдмийг хичээлээр...” зэрэг онч мэргэн үг хэллэг бий. Ийм учраас сурахын нэг гол үндэс нь хүн өөрөө болой. (Ер).

Хувь хүн сурах хүсэл тэмүүлэл, хичээл зүтгэл, зориг тэвчээр гаргаагүй нөхцөлд бүх төрлийн сургалтын үр дүн хоосон болж таарна. Түүнчлэн хүн өөрөө өөртөө багш байх нь суралцахын найдвартай баталгаа аж. Үүний тулд бие хүн өөрөө өөрөөсөө суралцах, өөрийгөө сургах, өөрийгөө бусдад мэдүүлэх нь зайлшгүй болж ирдэг (Жр) байна.



Өнөө цаг дор сурч сургах уламжлалт технологийг экологийн болон өнгөрсөн үйл явцтай нягт уялдуулан арай өргөн утгаар авч үзэх болж байна. Энэ нь зөвхөн тухайн үед өрөөл бусдаас бус орчин ахуй, суралцахуй байгаль ертөнц, өнгөрүүлсэн амьдралаас төдийгүй өөрөөсөө суралцах шаардлага зүй ёсоор урган гарч байгааг адил талт гурвалжин (Зр) дээр буулгаад

үзье.

Суралцаж байгаа этгээдийг шавь гэдэг. Өргөн утгаар хүн бүхэн шавь болой. Ийм учраас “сурагч” төвтэй сургалтын шинэчлэл Монголд хэдийнээ хийгдэж эхэлсэн. Сургалтын гурвалсан зарчмаар бол шавь буюу сурагч дараах (Ир) байдлаар төсөөлөгддөг.



2. Боловсролын тухайд



Боловсрол мэдлэг нь сургалтын гол хэсэг гэдэг маргашгүй асуудал (Бр) бөгөөд үүнийг дараах гурвалжин (Йр)-гаар бүдүүвчлэн үзүүлбэ.

Боловсрол хэмээх үг Монголчуудын бичгийн болоод ярианы хэлэнд харьцангуй бага хэрэглэгдэж иржээ. Харин боловсрох гэдэг нь үр тариа, жимс ногоон дээр илүүтэй хэлэгдэнэ. Сэтгэлгээний боловсрол гэдэг нь бясалгал бөгөөд оюуны аливаа бүтээлийг уншиж судлах явцад хүн тогтоох юм уу чээжлэхээс гадна ойлгох ба бясалгах мэдрэмжтэй болдог. Өөрөөр хэлбэл, сэтгэж бясалгаж сурч баймаажаа сая сэтгэх чадвар, сэтгэлгээний боловсрол олно гэсэн үг юм. Сэтгэлгээний буюу онолын боловсрол нь эрдэм мэдлэгийн дээд гэдгийг профессор Я.Хишигтийн өгүүллийн тэргүүн хэсэг (“Дал” сонин, №221/3, 2006)-т маш дэлгэрэнгүй бичигдсэнийг өөрсдийн тааллаар болгоон унших буй за.



Онол гэдэг нь өнөөгийн бидний ойлголтоор өөр хоорондоо шууд хамаарал бүхий таамаглал, шинэ санаа, хууль, зүй тогтол бөгөөд бие биеэ харилцан нөхцөлдүүлдэг ухагдахуун гэдгийг дараах гурвалжин (Кр)-гаар үзүүлэв.

Онол, практикийн нэгдэл, үр дүн, харилцан уялдааны тухайд бил Хууль, зүй тогтол гүн ухааны хичээлээр бишгүй заалгасан боловч үүнийг амьдрал ахуй дээр хэрэгжүүлэхдээ тал дээр хойрго хандсаар байна. Сургалтад хэтийлт болон өрөөсгөлөөр хандах нь манай боловсролын түүхэнд амь бөхтэй оршсоор ирснийг нуух юун. Товчоор хэлбэл, өнгөц онолдохоос хэтрээгүй бөлгөө. Харин онол, практикийн нэгдэл хангагдсан цагт үр дүн гарах нь зайлшгүй. Үүнийг дараах гурвалжин (Лр; Мр)-гуудаар төсөөлж болно.



Манай их, дээд сургууль, коллежийн дадлагын хичээл, хээрийн дадлага, багшлах болоод үйлдвэрлэлийн дадлага, ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн бодлого, дасгал, туршлага, мөн хичээлээс гадуур ажил (хөдөлмөр зуслан, туршлагын талбай, залуу байгальчдын станц ба дугуйлан), шинжилгээ судалгааны ажлын лабораторийн туршилт, хагас үйлдвэрлэл ба үйлдвэрлэлийн туршилт зэрэг нь бүтээх хийгээд дадал, чадвар суулгах аж байдлын сургалт юм. Онол, практик, сургалтын үр дүн нь боловсрол, шинжлэх ухааны үр дүн аль чиг салбарт дараах гурвалжин (Нр) -гаар төсөөлөгдөнө. Сургуулиудаас сайн багш болоод мэргэжилтэн бэлтгэх, шинэ сурах бичиг зохиох, заах аргын шинэчлэл хийх, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн байгууллагаас шинэ санаачилга оновчтой санал гаргах, тэргүүн туршлага болоод технологи нэвтрүүлэх нь практик зорилтоо хангаж буй хэрэг даруй мөн.



бүтээх чадвартай, амьдрах арга ухаанд суралцахыг уйгагүй хичээсэн нэгнийг эрдэмт хүмүүн (Өр) гээд амьдрахын тулд ажиллах, ажиллахын тулд мэдэх, мэдэхийн тулд сурах ба сургахын чухлыг онцлон үзсэн байдаг.

Нэн ялангуяа хийж бүтээхийг өндөр үнэлсэн үг хэллэг манайд цөөнгүй болоод “гар хөдөлбөл ам тосодно”, “эрхийг сурахаар, бэрхийг сур”, “явсан хүн яс зууна” тэргүүтэнд хийж бүтээх үйл ажиллагааны явцад юм сураад, тэр хэрээрээ хүн сайн сайхан амьдарч аж төрнө гэсэн утга санаа оршдогийг үгүйсгэхийн аргагүй юм (Пр).

Эрдэмт хүмүүний өөр нэг гол шинжийг ёс жудаг, мөс чанар гэдэг тул, “их мөрөн дөлгөөн, эрдэмт хүн номхон” хэмээх хэллэг монголчуудын дунд эртнээс хэвшжээ. Өндөр боловсрол, өв тэгш хүмүүжилтэй хүн ховор ч боловсрол хүмүүжил, авьяас чадварын аль нэг нь байхад багадахгүйн жишээг харъя. Зөвхөн өөрийн хүсэл тэмүүлэл, дур сонирхол, хичээл зүтгэл, авьяас чадварт дулдуйдан өөд ихийг бүтээсэн нэртэй хүмүүс, хөдөлмөрийн сайчуудыг захаас аваад нэрлэж болно. Биеэ дааж нарийн мэргэжил эзэмшиж өндөр боловсрол олсон төрийн шагналт, шинийг санаачлагч Увсын Сүрэнхор, Хөвсгөлийн Пүрэвдаш, төрийн шагналт, хөдөлмөрийн баатар дуучин Норовбанзад төрийн шагналт, эрдэмтэн-зохиолч Ш.Нацагдорж, тольч мэргэн Я.Цэвэл, Судар бичгийн Хүрээлэнгийн анхны дарга Сангажавын Жамъян нар алдрын жолоог атгах хүртлээ албан тээд боловсролгүй явсан хүмүүс. Түүгээр үл барам авьяас чадварыг бүр багад нь илрүүлэн дэвших үндсэн дээр хутагт хувилгаадыг тодруулан, улмаар тэдний мэдрэмжийг дасгалжуулан төлөвлүүлж байжээ. Эл асуудлыг улам лавшруулан ахмад эрдэмтэн Т.Соднойн “Монголчуудад хүмүүжлийн өөрийн гэх гүн ухаан бий” (“Дал” сонин, No 220/2, 2006) нийтлэлтэй товч танилцъя. Тэр бээр дурсамж нийтлэлийнхээ толгойд ...“Хүүхдийг хөдөлмөрөөс чөлөөлөх мэргэн ухаан ба миний бага нас” гэсэн тун ёжтой зүүлт хийснийг та бүгд тунгаан болгоох буй заа. Гар болоод ухааны ур дүйгээ амин зуулга болгож чадах тэр авьяасыг эх нь бүхнээс түрүүнд ажаад хүүгээ ажил хөдөлмөрөөр хүмүүжүүлж эдийн засгийн аргаар амьдрах, хожмоо гүн сэтгэлгээтэй номын хүн болох зам мөрийг нь засаж, улмаар төр нийгэмдээ нэр хүндтэй эрдэмтэн болгосон нь үнэхээр монгол ухаан ажээ. Эндээс хүүхдэд өөрт нь таарсан хөдөлмөрийн чухлыг мэдэж болно. Гэхдээ тэр нь тэдний нас, хүйс, хүсэл, сонирхол, авьяас чадал, ур ухааны мэдрэмжид тохирсон байх учиртайг хэн үгүйсгэх сэн билээ. Нөгөөтээгүүр бидний дунд “буруу өссөн хүүхэд, бухын хүзүүнээс хатуу” гэдэг үг бий. Энэ нь хүнийг “дахин” хүмүүжүүлэхийн хэцүүг бие сэтгэлээрээ мэдэрсэн, оросын нэрт сурган хүмүүжүүлэгчийн бичсэн тэй яв цав тохирдгийг хэлэхэд илүүдэх юун. Зөв хүмүүжил нэгэнт олоогүй хүүхдийн мэдрэмжийг дасгалжуулан аливаад сургаж авьяас чадвар, ур ухаан, эрдэм мэдлэгийг нь дээшлүүлнэ гэдэг тийм амар ажил биш тул хэн хүнийг бүр багаас нь зөв сайхан хүмүүжүүлэхийг эцэг эх, гэр бүлийн хэмжээнд, ясли, цэцэрлэг, бага ангиас нь анхаарах явдал зүйн хэрэг бөгөөд өнөө үед хүүхдийг бүр эхийн хэвлийд байхаас нь хүмүүжүүлэх тухай ярьж бичиж байгааг эл дашрамд дуулгая.

Бид хүмүүжил, боловсрол, сургалтын талаар та бүхэнтэй саналаа хуваалцлаа. Боловсролтой нь хүмүүжилгүй (архи уух, тамхи татах, биеэ тоох, хар амиа бодох, нэр төр хөөцөлдөх гэх мэт.) хүмүүжилтэй нь боловсролгүй (бололцоо нөхцөл нь хангагдаагүй), хүмүүжил боловсролтой нь авьяас билэг, ур чадвараа таньж мэдэн өөрийгөө нээж чадаагүй,

3. Хүмүүжлийн тухайд

Жирийн амьдрал, ардын уламжлалт сурган хүмүүжүүлэх ухаанд хүмүүжих, хийж бүтээхийн ур чадварыг хослуулан амьдрах арга ухаан, авьяас чадвар, ёс горимд тулгууртай сургалтыг эрхэмлэж иржээ (Ор).

Энэ нь “ёс ёмбогор, төр төмбөгөр”, “зүгээр суухаар зүлгэж суу”, “эрүүл биед саруул ухаан” зэрэг хэллэгээр шууд илэрдэг.

Монголчууд бусдын сургаалыг сонсох хүмүүжилтэй, юм сурч мэдээд хийх



таньж мэдсэн ч түүнийг хөгжүүлээгүй, эсвэл нээх нөхцөлийг бүрдүүлж хараахан бараагүй байх нь амьдралд цөөнгүй боловч энэ нь нийгмийн зүй тогтолт үзэгдэл биш болов уу.

4. Боловсролын тогтолцоо, сургалтыг шинэчлэх тухайд

Бид хүмүүжил боловсрол, сургалтын гурвалсан зарчмуудыг задлан шинжиллээ. Эдүгээг иртэл бид гаднын сургалтын хэлбэр, хэв маягийг яг дуурайх юм уу хуулбарлан ашиглаж иржээ. Үүнээс алдсан, хожсон нь тэнцүүхэн бололтой юм. Профессор Я.Хишигтийн хэлсэнчлэн ардын уламжлалт сурган хүмүүжүүлэх ухааныг төдийлөн хайхарсангүй, өөрийн улс орон, үндэстний өвөрмөц онцлогийг анхаарсангүй, дэлхий нийтээр даяаршиж буй сургалтын оновчтой арга барилыг анзаарсангүй Ингээд бодоход, Монголчуудын хэлдгээр “Галууг дуурайж хэрээ шавардах”, “Уулын бугыг хараад, унасан морио хаях”, гэдэгтэй бараг адилхан бодлого хэрэгжүүлсэн байна гэхэд хилсдэх зүйлгүй мэт. Жишээлбэл: бүгдийг тал бүрийн боловсролтой, өв тэгш хүмүүжилтэй, түүгээр үл барам толгой дараалан дээд боловсролтой болгож, эрдмийн ажилтан бүрийг эрдмийн зэрэг хамгаалуулах урай дор ажиллаж ирсэн үе ч байв. Хэн хүнийг алдартай дуучин, нэртэй жүжигчин, тамирчин, эрдэмтэн болгох боломж хүмүүний хорвоод байдаггүйг мэдсээр атал хувь хүний авьяас билэг, ур чадвар, оюуны чадамжийг түшиглэн онцгой мэдрэмжийг нь төлөвшүүлэн хөгжүүлэх явдал манайд тун хоцрогдонгүй байна.

Нийгмийн бүх гишүүдийг ижил түвшинд хүргэж болдоггүйн учир шалтгаан нь бие хүний төрөлхийн ур ухаан, авьяас чадлыг нөхцөлдүүлэгч ген бөгөөд түүний илтгүүр болсон бодот хүчин зүйлийг олж харах, төлөвшүүлэх нь тухайн нийгмийн байдал, үндэстний онцлог, өв уламжлал, магадгүй шашин шүтлэгээс ч хамаарч мэдэх асуудал байдаг. Дашрамд хэлэхэд, өнөөдөр манайд төр, шашин, шинжлэх ухааны зааг ялгаа багасаж, тэдгээрийн нийгэмд эзлэх байр суурь, зохистой харьцаа илтэд алдагдсан учраас шашин, шинжлэх ухаан, боловсролын талаар төрөөс барих цэгцтэй бодлого илтэд үгүйлэгдэж байна.

Нийгмийн давхарга, нийт олны дунд шашин шүтлэг, зан үйлийн чанартай мэдлэг боловсрол давамгайлж болзошгүйг төр засгаас анхаарах цаг нэгэнт болжээ. Энэ бүхэн шинэчлэлийг зүй ёсоор шаардаж байна. Иймээс ч боловсролын тогтолцоог шинэчлэх, сургалтын арга барилыг өөрчлөх талаар Монгол төрийн бодлогод тусган хэрэгжүүлэх олон сайхан санааг багш, мэргэжилтэн, эрдэмтэн судлаачдаас дэвшүүлж байгааг хүлээж авч хэрэгжүүлэхээс өөр аргагүй юм.



Улс орны онцлог, өвөрмөц нөхцөл байдал, мөн сурч, сургах арга бодлогын технологид бүрэн нийцсэн монгол төрийн боловсролын бодлого, Үндэс шинэ тогтолцоо нь уламжлал, шинэчлэл, тэдгээрийн зохистой Зохист тогтолцоо харьцаан дээр тулгуурлах учиртайг дараах

адил талт гурвалжингаар төлөөлүүлэв (Рр).

Эрхэлдэг аж ахуй, эдэлдэг мал сүрэг, эрхэмсэг оршихуй, эрс тэс уур амьсгал, өргөн дэлгэр нутаг, цөөн хүн ам тэргүүтнээр бусдаас эрс ялгаатай цорын ганц орон

Монгол учраас үндэстний онцлог, улс төрийн төлөвшил, нийгмийн ухамсар, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн түвшин (нэн ялангуяа дэд бүтэц), хүн амын байршил, суурьшил, байгалийн баялаг тэргүүтэнд холбогдох амин чухал асуудлууд Монгол төрийн бодлогод тусгалаа олж, амьдралд хэрэгжих учиртайг энд зориуд цохон тэмдэглүүштэй.



Эдгээр онцлогийг зангидан дараах адил талт гурвалжин (Ср)-гаар төлөөлүүлэе. Манай боловсролын тогтолцооны үндсэн бүрэлдэхүүн нь ерөнхий боловсролын сургууль, тусгай мэргэжлийн сургууль, их орон ба дээд сургуулиуд байсаар ирсэн бөгөөд үүнээс тусгай мэргэжлийн сургууль нь коллеж нэртэй болж, улс орны бүтээн байгуулалтад гол Нийгэм, эдийн засгийн онцлог СА үүрэг бүхий техник мэргэжлийн сургууль үндсэндээ жагсаалтаас хасагджээ.

Сургах ажлын эцсийн үр дүн, практик өгөөж нь судалгаа шинжилгээ, сургалт - үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх суурь төдийгүй Монгол төрийн боловсролын бодлогод чухал байр эзлэх учиртайг давтан хэлэх нь зүй. Нэн ялангуяа техник мэргэжлийн сургууль олшрух тусам нийгмийн хөгжил дэвшил түүнийг даган хурдсаж ирдэг. Ерөнхий сайд асан Ц.Элбэгдорж



үүнийг зөв талаас нь харж санаачилгатай ажиллаж байсныг Чинагш улам гүнзгийрүүлэх явдал улс орны хэмжээний өндөр шаардлага болоод байна.

“Сургалтын шинэчлэлийг сургуулиас эхэлье” уриан дор магистр багш Д.Банзрагч “Хичээлийг шинэчилье” (“Дал” сонин, №220/2.,2006) нийтлэлийнхээ эхэнд дараах зүүлт хийснийг гурвалсан Шинэчлэл зарчмын нэг хэлбэр гэж үзэхээс аргагүй (Тр).

Хичээл, сургууль бол боловсролын тогтолцооны цөм учраас хичээл заах аргын шинэчлэл нь боловсролын тогтолцоо, сургалтын явцыг шинэ шатанд гаргах зангилаа асуудал гэсэнтэй санаа нэг байна.

Магистр багш Д.Банзрагчийн хэлснээр сурагчийн сурах ба багшийн сурах ном ялгаатай байх учиртай. Үнэндээ бид өнөөг иртэл аль чиг шатны сургуульд багш, сурагч хоёр “нэг” номтой явж иржээ. Боловсрол болоод сургалтын шинэчлэлийн эрин үед сурагчийн сурах ба унших бичиг, багшийн сурах ном, гарын авлагыг заавал ч байлгах учиртайг дараах гурвалжин (Ур)-гаар бүдүүвчилье.



Түүнчлэн олон жилээр суралцах ерөнхий боловсролын шинэ тогтолцооны талаар их соён гэгээрүүлэгч, эрдэмтэн-зохиолч Л. Түдэв гуайтай санал нэг байна. Тэр бээр “Багш” сэтгүүлд өгсөн ярилцлагадаа (“Дал” сонин, №220/2, 2006) бага дунд сургуулиас аваад бакалаврын сургалтыг дамжин 20-иод жил суралцаад юм бүтээх ид насаа өнгөрөөх нь зохисгүй хэрэг хэмээжүй. Магистрантур, аспирантур, докторантурын сургалт, тэдгээрийн хоорондох завсрын хугацааг тооцвол 30 гаруй жилийг зөвхөн суралцахад зориулах болж байна. Гэтэл Герман улсад 30 хүртэлх насандаа сургалтын дээрх бүх шатыг дамжаад 35 нас хүртлээ профессорын зиндаанд өрсөлдөх эрхтэй аж. Энэ бол миний мэдэх ганцхан улсын жишиг.

Монгол хүүхдийн сэтгэлгээ, оюуны чадамжийг харсан ч ерөнхий боловсролын 11(12) жилийн сургалт манайд төдийлөн тохирохгүй байх маягтайг харгалзан сургалтын ачаалал, шахуу Төлөвлөгөөний талаар магистр багш Д.Банзрагч үнэмшилтэй дүгнэлт хийснийг дурдалгүй өнгөрч боломгүй.

Бүх төрлийн хичээлээр сурагчдыг тал талаас нь шахахгүйгээр, харин сурагчдын авьяас чадвар, хүсэл сонирхолд нийцсэн сонгон суралцах хичээл, гүнзгийрүүлсэн сургалттай сургуулиудын тоог олшруулмаар санагдана. Манайхаас гадаад оронд шилжин суралцагчид очсон даруйдаа тэр орны ерөнхий боловсролын сургуулийн шаардлагыг хангасны дагууд 1-2 ангийг алгасан суралцаж буй баримт цөөнгүй болой. Нөгөөтээгүүр бидэнд гүйлгэн ухаан, гун сэтгэлгээнээс гадна өв уламжлал, өвөрмөц аж төрөх ёсон бий билээ. Сургалтыг олон жил болгох асуудлыг шийдвэрлэхдээ амьдрахуйн боломж, ахуй нөхцөл дээшилж, цаг зав ихсэхийн хирээр хувь хүний ухаан ужиг задарч залхуу хойрго боломтгой хүмүүн заяа хийгээд сэтгэхүйн бусад онцлогийг харгалзах нь чухал болов уу.

“Хүнийг хүн болгож байгаа хамгийн гол хүчин зүйл бол хүмүүний мэдрэмж” гэсэн нэрт сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйч Я.А.Коменскийн үзэл бодлыг бүтээлчээр тусган авч, боловсролын тогтолцоо, сургалтын арга, хичээлийн агуулга хэлбэрийг дэс дараатайгаар өөрчлөх шинжлэх ухааны үндэслэлийг профессор Я.Хишигт (“Дал” сонин, №221/3, 2003) Онолын үүднээс дэвшүүлснийг цаашид мөрдөхөөс аргагүй мэт санагдана.

Тэр бээр мэдрэмжийг “сэрэхүй, хүрэлцэхүйгээс эхлээд хүртэхүйгээр уламжлан сэтгэж танин мэдэхүйг хамарсан бие махбод, уураг тархи, сэтгэц, хэлэхүйн нэн өвөрмөц үйл ажиллагаа” хэмээгээд үүнд нотолгоо болгон дараах эшлэлийг дээрх эрдэмтний бүтээлээс эш татжээ.

“Хүнээс ангид орших бүхэн хүмүүний оюун ухаанд нэвтрэн орох үүд хаалга бол зөвхөн мэдрэмж... Мэдрэмж нь мэдлэгийн анхдагч бөгөөд байнгын дасгалжуулагч. Ийм учраас мэдрэмжийг давын өмнө дасгалжуулж, төлөвшүүлэн хөгжүүлбэл зохино. (Коменский Я.А. Избранные сочинения. Т.1.М., 1982, стр 551-552).

Гагцхүү мэдрэмжийг төлөвшүүлэн хөгжүүлснээр хүмүүнд хүмүүжил (ёс суртахууны, хөдөлмөрийн, бие бялдрын), боловсрол (мэдлэг) олгох, ур ухаан суулгах (технологи эзэмших, авьяас билгийг нь хөгжүүлэх бөгөөд үүнийг бодот мэдлэг, дадал, чадвар болгоход нэн өвөрмөц арга (заах, заалгах, бие даах, сэтгэн бясалгах хэрэгтэй нь онолын дээрх үндэслэлээс тодорхой харагдаж буй. Профессор Я.Хишигт мэдрэмж хийгээд мэдлэгийн тухай чинагш тайлбарлахдаа “Аливаа боловсролын эх үндэс болдог мэдлэг бол сэрэхүйгээс эхлээд хийсвэрлэн танин мэдэхүйг хамарсан нэн өргөн цар хүрээтэй өвөрмөц туршлага бөгөөд мэдлэг уур мөн чанараараа мэдрэмжийн туршлагын хуримтлал” (“Дал” сонин, No221/3, 2006) хэмээгээд үүнтэй холбогдсон гурвалсан зарчмыг гаргаж иржээ (Үр).



Эдгээр мэдлэгийг мэдрэх, мэдрүүлэх замаар бодот мэдлэг буюу дадал, чадвар болгогчийг дараах дүрс (Фр)-нээс үзнэ үү.

Профессор Я.Хишигт (“Дал” сонин, No224/В, 4-р нүүр, 2006) Өнөөгийн Монголын боловсролын бодлого, сургалтын арга барилыг шүүн тунгаахдаа,, ... Орчин үеийн боловсрол, хүмүүжүүлэн сургах тогтолцоонд төвлөрөл, дагналт ямар түвшинд байгааг тоймлохын тулд цэцэрлэгээс эхлээд ЕБС, коллеж, дээд, их сургуульд нэг өдрийн дотор хэдэн төрлийн хичээл солбилцож ордгийг санацгаая. Өөрөөр хэлбэл орчин үеийн хүмүүжил, сургалтын үйл ажиллагаа нь цэцэрлэгээс аваад их сургууль, тэр ч атугай магистрантур, аспирантур хүртэл мэдрэмжийн төлөвшил, хөгжлийн хувьд дагнасан бус, харин ч анхаарал ой тогтоомж

мэдрэмж нь сарнихаар мөн чанартай зохион байгуулагдсан юм биш биз “хэмээжүй”.

Аль чиг улсын боловсрол сургалтын тогтолцоо өргөн цар хүрээтэй, олон шатлалтай, баялаг агуулгатай, түүнийг зохистой хэмжээнд бүрдүүлэхэд олон жилийн туршлага, нөр их хөдөлмөр, гүн гүнзгий сэтгэлгээ, ухаалаг зорилго, зорилт шаарддаг чимхлүүр ажил боловч олны бодол-оломгүй далайд дусал төдийг нэмэрлэх “их” санааны үүднээс зарчмын зарим асуудал, тэдгээрийн уялдаа холбоог адил талт гурвалжингаар төсөөлж Та бүгдийн тархи оюуныг чилээсэндээ өөрийн зүгээс хүлцэл өгчсүү.